

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 11 дүгээр
сарын 17-ны өдөр

№.....01/23

Улаанбаатар хот

Глобал Монголиа Холдингс ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("Хурал")-ыг 2023 оны 11-р сарын 17-ны өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сонор плаза 602 тоот танхимд хуралдуулав.

Хурлын Тооллогын комиссоор хуульч М.Лхамсүрэн, Хурал зохион байгуулах комиссоор Хан Гю Бун, С.Энхзул нар тус тус ажиллав.

Хурлын дарга Тооллогын комиссын дарга М.Лхамсүрэн хурлын ирцийг танилцуулав.

2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргаж хурал хуралдуулах тухай шийдвэрийг 2023 оны 10 дугаар сарын 07-ны өдөр гаргасан. Журмын дагуу хурал хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоногийн дараа ээлжит бус хурлыг хуралдуулах бөгөөд өнөөдөр буюу 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хуралдаж байна. Хурал хуралдуулах тухай шийдвэрийн тухай мэдээллийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсэн.

Хуралдааны ирцийг танилцуулвал, Компани нь 107,306 ширхэг энгийн хувьцааг гаргасан. Нийт 64,600 ширхэг энгийн хувьцааг эзэмшигч Пак Чан Су /Park Chan Soo/, Чан Кён Суг /Chang Kyoung Suk/ нар 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр Хан Гю Бун-д итгэмжлэл олгосон байна. Энэхүү итгэмжлэл нь БНСУ-д үйлдэгдсэн бөгөөд Апостиль-р баталгаажиж, 2023.11.17-ны өдөр Монгол хэлээр орчуулагдаж ирсэн байна. Тиймээс Хан Гю Бун нь хувьцаа эзэмшигч Пак Чан Су болон Чан Кён Суг нарыг төлөөлөх бүрэн эрхтэй этгээд мөн болно. Итгэмжлэлийн агуулгыг уншиж танилцуулбал:

“БНСУ-ын иргэн Пак Чан Су нь Хан Гю Бунд Глобал Монголиа Холдингс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцож шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, тэмдэглэлд гарын үсэг зурах, Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчийн бүх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг олгосон байна.”

Ийм учраас саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50%-иас дээш нь буюу Компанийн нийт хувьцааны 60,2%-ийн хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хуралд өөрийн биеэр ирсэн учир хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг мэдээлэв.

Хурлын дарга Хурлыг нээж, Хурлын дэг болон Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Хурлаар танилцуулах асуудалд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай;
2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай;
3. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай;
4. Бусад

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хэлэлцэх асуудал 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай.

Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүн байна.

ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнээр Ким Ки Хюун, Бэк Квангюэл, Хан Бэк, И Дун Ву, Ким Ду Хван, Мөнхсайхан овогтой Лхамсүрэн, Энхтайван овогтой Гандиймаа, Цэвэгсүрэн овогтой Тогоо, Баярмаа овогтой Ананд нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнд тус тус нэр дэвшүүлж байгаа тухай болон нэр дэвшиж буй гишүүдийн танилцуулгыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулав. Хувьцаа эзэмшигч та бүхэн дээрх гишүүдийг ТУЗ-ийн гишүүнд томилох тухай саналаа өгнө үү.

Хан Гю Бун: Хэлэлцэх асуудал 1 буюу дээрх 9 гишүүнийг Компанийн ТУЗ-р томилохыг дэмжиж Компанийн нийт хувьцааны 60,2%-ийн хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч миний бие зөвшөөрч байна. Цаашид Компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, чухал асуудлыг ТУЗ-ийн гишүүд маань шийдвэрлэхээр томилсугай.

Хэлэлцэх асуудал 2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай.

2023 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 1,000,000 ширхэг хувьцааг нэмж гаргахаар төлөвлөж байна. Цаашид нийт хувьцааны тоог 250,000,000,000 хүртэлх хэмжээгээр нэмэгдүүлэхээр алсдаа төлөвлөж байгаа ч эхний ээлжинд 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдөр 1,000,000 ширхэг хувьцааг нэмж гаргах тухай асуудлыг зөвшөөрч байна уу.

Хан Гю Бун: Миний бие дэмжиж байна. Хувьцааг нэмж гаргах тухай асуудлыг зөвшөөрсөн.

Хэлэлцэх асуудал 3. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай.

Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай асуудал дээр бидний анхаарах зүйл нь Компанийн тухай хууль, засаглалын кодекс болон эрх бүхий байгууллагуудын холбогдох шаардлагуудад нийцүүлэн гаргах нь чухал. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа МХБ болон СЗХ-ны шаардлагын дагуу үйл ажиллагааны голлох чиглэлийг баримтлан үүнтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөө гарган тайланд тусган, хэрэгжүүлэх нь чухал. Энэхүү дэлгэрэнгүй үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хуралдах Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудалтай уялдуулан батлах юм.

Хан Гю Бун: Гуравдугаар хэлэлцэх асуудлыг мөн зөвшөөрч, цаашдын компанийн үйл ажиллагааг тогтвортой, хууль, журамд нийцүүлэн чиглүүлэн явахыг хүсье.

Хэлэлцэх асуудал 4. Бусад /Компанийн тухай хуульд заасан/

Компанийн Гүйцэтгэх захирлыг шинээр томилох тухай асуудлыг хэлэлцье. ТУЗ-ийн гишүүд дундаас Бэк Квангюэл-г гүйцэтгэх захирлаар томилох тухай саналтай байна. Өнөөдрийн хурлаар Компани шинэ ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг томилж байгаа билээ.

“ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС” ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Бусад хэлэлцэх асуудлын хүрээнд буюу Гүйцэтгэх захирлыг томилох тухай асуудлыг шинээр томилогдож буй ТУЗ цаашид хуралдан хэлэлцэхийг үүрэг болгоё.

Хан Гю Бун: Компанийн ТУЗ нь хуралдаж гүйцэтгэх захирлыг шинээр томилох тухай асуудлыг хэлэлцэхийг миний бие дэмжин, зөвшөөрч байна.

Тооллогын комиссын дарга М.Лхамсүрэн: 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцсэн асуудлуудын саналын дүнг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал 1: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 60,2%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 2: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 60,2%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 3: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 60,2%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.

Хэлэлцэх асуудал 4: Компанийн хувьцаа эзэмшигчдийн 60,2%-ийн саналаар буюу хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлагдлаа.

Хурлын дарга: “Глобал Монголиа Холдингс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлуудыг бүрэн хэлэлцэж дууслаа. Шинэ ТУЗ-ийн гишүүд маань Компанийн төлөө сэтгэл шулуудан, зорилго нэгтэй ажиллаж, цаашдын үйл ажиллагааг өргөжүүлэн дэлгэрүүлж ажиллана гэдэгт итгэлтэй байна. Ингээд өнөөдрийн хурлыг хаасныг мэдэгдэж байна.

Хурлын дарга Хурлыг 10:40 минутад хаав.

ХУРЛЫН ДАРГА:...../ХАН ГЮ БУН/

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:...../Г.ХАЖИДМАА/



“글로벌 몽골 홀딩스” JSC

주주총회 회의록

2023 년 11 월 17 일

No.....

울란바토르시

글로벌 몽골 홀딩스 JSC(이하 “회사”라 함)의 임시 주주총회(이하 “회의”라 함)를 2023 년 11 월 17 일 오전 10 시에 울란바토르시 수흐바토르구 8 코루 서너르 플레이스 602 호에서 소집하였습니다.

회의 정산 위원회를 변호사 M. Lkhamsuren, 회의 소집 위원회를 한규봉과 S.Enkhzul 이 맡았습니다.

회의 의장인 정산 위원장 M. Lkhamsuren 이 회의 출석을 발표하였습니다.

2023 년 09 월 20 일에 의결권 있는 주식의 10 프로와 그 이상을 소유하는 주주가 제안과 요구사항을 제출하여 2023 년 10 월 07 일에 회의 소집 결정을 하였습니다.

규정에 따르면 회의 소집 결정일로부터 40 일 안에 임시 회의를 소집되어야 하며, 오늘 2023 년 11 월 17 일에 개최하였습니다. 회의 소집 결정에 관한 사항을 언론 매체, 브로커 및 딜러 회사를 통해 주주들에게 공지했습니다.

참석자에 따르면 회사는 보통주 107,306 주를 발행하였습니다. 보통주 총 64,600 주를 소유하는 박찬수와 장경숙은 2023 년 9 월 8 일에 한규봉에게 위임했습니다. 본 위임장은 대한민국에서 아포스티유 인증을 받아 2023 년 11 월 17 일에 몽골어로 번역되었습니다. 따라서 한규봉은 주주 박찬수와 장경숙을 대리할 권한을 가진 자입니다. 위임장의 내용을 읽어드리면:

“대한민국 국민 박찬수 본인은 한규봉에게 글로벌 몽골 홀딩스 JSC 의 주주총회에 참석하여 의결권을 행사하고, 주주총회 결의 및 의사록에 서명하고, 몽골 회사법에 명시된 주주총회의 모든 권리를 이행할 권한을 위임한다.”

따라서 의결권 있는 주식의 50% 이상인 회사 주식의 총 60,2%의 소유하는 주주의 대리인이 회의에 참석하였으므로 회의가 유효하다는 것을 발표했습니다.

회의 의장이 호의를 개최하여 회의 순서 및 회의에서 논의할 사항을 소개했다. 회의에서 논의할 사항:

1. 이사회 임명;
2. 자본금 변동;
3. 회사 사업계획 결정;
4. 기타;

논의 사항 1. 이사회 임명

“글로벌 몽골 홀딩스” JSC

주주총회 회의록

회사 정관 규정에 따라 이사회는 9 인으로 구성하며 이 중에 사내이사가 6 명, 사외의사는 3 명이다.

이사회 구성원으로 김기현, 백광열, 한백, 이동욱, 김두환, Munkhsaikhan Lkhamsuren, Enkhtaivan Gandiimaa, Tsevegsuren Togoo, Bayarmaa Anand 을 이사회 사내이사 후보로 추천하여 후보자 소개를 회의 소집 위원장이 소개하였다. 주주 여러분이 이사회 임명에 투표해 주세요.

한규봉: 회사 주식의 총 60.2%를 소유하는 주주의 대리인으로서 위 9 명의 후보자들을 회사의 이사회로 임명하는 것을 창선합니다. 앞으로 회사 활동을 지도하고 중요한 문제를 이사회 이사들이 해결하도록 임명하세요.

논의 사항 2. 자본금 변동

2023 년 12 월 10 일에 1,000,000 주의 추가 주식을 발행하기로 계획하고 있습니다. 앞으로 주식을 총 250,000,000 주까지 추가하기로 계획하고 있으며 우선 2023 년 12 월 10 일에 1,000,000 주의 추가 주식을 발행하는 것을 찬성하십니까?

한규봉: 찬성합니다. 주식을 추가로 발행하는 것을 허락합니다.

논의 사항 3. 회사 사업 계획 결정.

회사 사업 계획 결정과 관련하여 회사법, 지배구조 코덱스 및 관할 자치단체의 요구 사항에 준수하는 것이 중요합니다. 사업 계획을 결정할 때에는 몽골 증권 거래소 금융 규제 위원회의 요구 사항에 따라 사업 중심 방향을 따라 이와 관한 사업 계획을 작성하여 보고서에 올리는 것이 중요합니다. 이 자세한 사업 활동 보고서 및 계획을 정관 변경 사항을 논의할 2023 년 12 월 10 일 소집할 회사 주주총회에서 결정될 예정입니다.

한규봉: 이 사항을 찬성하며 앞으로 회사 운영이 안정하고 법률 및 정관에 준수하여 지도하기를 바랍니다.

논의 사항 4. 기타 /회사법에 따름/

회사의 새로운 최고 경영자 선임에 대해 논의하겠습니다. 이사회 구성원 중에서 백광열을 최고 경영자로 선임하는 것을 추천합니다. 오늘 회의에서 회사는 새로운 이사회를 임명하였습니다. 기타 논의 사항 최고 경영자 선임에 관한 사항을 새로 임명된 이사회가 결정하도록 합니다.

한규분 : 회사 이사회가 회의하여 최고 경영자를 선임하는 것을 찬성합니다.

회의 정산 위원장 M. Lkhamsuren: 2023 년 11 월 17 일 임시 주주총회에서 논의한 사항의 결과를 발표하겠습니다.

“글로벌 몽골 홀딩스” JSC

주주총회 회의록

논의 사항 1. 회사 주주 60,2%의 찬성으로 즉, 회의에 참석한 주주의 100% 찬성으로 결정되었습니다.

논의 사항 2. 회사 주주 60,2%의 찬성으로 즉, 회의에 참석한 주주의 100% 찬성으로 결정되었습니다.

논의 사항 3. 회사 주주 60,2%의 찬성으로 즉, 회의에 참석한 주주의 100% 찬성으로 결정되었습니다.

논의 사항 4. 회사 주주 60,2%의 찬성으로 즉, 회의에 참석한 주주의 100% 찬성으로 결정되었습니다.

회의 의장: “글로벌 몽골 홀딩스” JSC 의 임시 주주총회에서 논의할 사항을 전부 논의하였습니다. 새로 임명된 이사회가 회사를 위해 하나의 목적으로 일하고 앞으로 회사의 활동을 확장할 것이라고 확신합니다. 오늘의 회의가 종료되었습니다.

회의 의장이 회의를 오전 10 시 40 분에 종료하였습니다.

회의 의장:/한규봉/

회의록 작성:/G.Khajidmaa/

